

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн “Эм эргэлтийн сан” ОНӨААТҮГ -ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2024/03/НА-СТА-ОНА

Цахим хуудас: www.dornogovi@audit.gov.mn Дорноговь аймаг Сайншанд сум 2024 он	Дорноговь аймаг дахь төрийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий Утас: 261665, 70522734 Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn Аудитын менежер: У.Оюунтүлхүүр Утас: 70523020 Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn Ахлах аудитор/аудитор: Д.Сайнжаргал Утас: 99080493 Цахим хаяг: info.iedca@gmail.com Интакс Эксперт Ди Си ХХК-ийн захирал: Д.Сайнжаргал Утас: 99080493 Цахим хаяг: info.iedca@gmail.com
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....
 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
 3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....
 4. Аудитын тайлан
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
 6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (976) 7052 2734

Цахим хуудас: dornogovi@audit.gov.mn

2024.03.15 № 1-6/298

танай _____-ны № _____-т

ЭМ ЭРГЭЛТИЙН САН
ОНӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ Б.ЖАМЬЯНЖАВ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эм эргэлтийн сан ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Эм эргэлтийн сан ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Эм Эргэлтийн Сан ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн дараах залруулаагүй алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс хэтэрсэн бөгөөд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20.2.5, 20.2.6, 20.2.9 гэсэн заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх, үнэн зөв байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- ✓ Бараа материалын эцсийн үлдэгдлийг санхүү байдлын тайлангийн эхний эцсийн үлдэгдэл, Үр дүнгийн тайлангийн өртөг, Мөнгөн гүйлгээний тайлангийн бараа материал худалдан авсан мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайланд хийгдсэн залруулга, санхүүгийн тайлангийн тодруулга болон бусад журнал, аудитад ирүүлсэн бусад тайлангуудтай зэрэгцүүлж үзэхэд тайлангуудын мэдээлэл хооронд уялдаа холбоогүй материаллаг зөрүүтэй байна.
- ✓ Он дамнасан муу авлагыг барагдуулаагүй, тус муу авлагаас 7.7 сая төгрөгийн авлагад тооцоо нийлсэн акт үйлдээгүй.
- ✓ Азифарм ХХК-д төлөх 116.8 сая төгрөгийн өр төлбөрт гэрээний дагуу тайлант онд нийт 33.1 сая төгрөгийн алданги төлсөн.
- ✓ Санхүүгийн байдлын тайлан, Орлогын дэлгэрэнгүй тайлан, Мөнгөн гүйлгээний тайлангийн уялдаа холбоог шалгаж үзэхэд борлуулалтын

010020090

орлого, мөнгөн орлого хооронд 13.5 сая төгрөгийн зөрүүтэй илэрхийлэгдсэн байна.

- ✓ Тайлант онд 44.1 сая төгрөгийн залруулгыг Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга буюу хуримтлагдсан ашиг дансанд өглөгийн дансны үлдэгдлийг тааруулах зорилгоор хийсэн.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна.

Дорноговь аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 сарын 05 өдрийн 15/10 тоот тогтоолоор тус байгууллагыг татан буулгаж, хувийн өмчлөлд шилжүүлэх зорилгоор нээлттэй дуудлага худалдааны аргаар худалдаалан хувьчлах шийдвэр гарсан байна.

Бусад асуудлын хэсэг

Эм Эргэлтийн сан ОНӨААТҮГ-ын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ГАН ӨЛЗИЙ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Үлдэгдэл	
		1 сарын 1	12 сарын 31
1.1.01	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	26,263,903.78	17,969,649.01
1.1.02	Дансны авлага	168,615,485.13	158,653,928.48
1.1.06	Бараа материал	216,333,788.65	36,055,449.24
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	411,213,177.56	212,679,026.73
1.2.01	Үндсэн хөрөнгө	79,508,178.03	63,471,420.13
1.2.02	Биет бус хөрөнгө	2,874,575.75	2,227,939.39
1.2.03	Биологийн хөрөнгө		
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	82,382,753.78	65,699,359.52
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	493,595,931.34	278,378,386.25
2.1.1.01	Дансны өглөг	383,111,483.93	308,780,826.58
2.1.1.03	Татварын өр	32,833,915.48	72,289,509.39
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	415,945,399.41	381,070,335.97
2.2	ӨР ТӨЛБӨРИЙН НИЙТ ДҮН	415,945,399.41	381,070,335.97
2.3.01	Өмч -төрийн	189,682,669.33	189,682,669.33
2.3.08	Эздийн өмчийн бусад хэсэг	1,770,000.00	1,770,000.00
2.3.09	Хуримтлагдсан ашиг	-113,802,137.40	-294,144,619.04
2.3.11	ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	77,650,531.93	-102,691,949.71
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	493,595,931.34	278,378,386.26

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого /цэвэр/	1,206,998,784.04	167,589,806.70
2	Борлуулалтын өртөг	804,801,748.53	161,575,291.28
3	Нийт ашиг /алдагдал/	402,197,035.51	6,014,515.42
8	Бусад орлого	873,735.00	
10	Орлогын дүн	873,735.00	-
9	Борлуулалт, маркетингийн зардал	147,140,981.84	55,428,261.96
10	Ерөнхий ба удирдлагын зардал	359,842,839.72	26,608,882.02
12	Бусад зардал	25,804,051.38	60,143,790.37
12.1	Зардлын дүн	532,787,872.94	142,180,934.35
18	Татвар төлөхийн өмнөх ашиг	-129,717,102.43	-136,166,418.93
20	Татварын дараах ашиг /алдагдал/	-129,717,102.43	-136,166,418.93
22	Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/	(129,717,102.43)	(136,166,418.93)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2021 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	189,682,669.33	1,770,000.00	38,185,465.03	229,638,134.36
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-		-22,270,500.00	-22,270,500.00
Залруулсан үлдэгдэл	189,682,669.33	1,770,000.00	15,914,965.03	207,367,634.36
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-		-129,717,102.43	-129,717,102.43
2022 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	189,682,669.33	1,770,000.00	(113,802,137.40)	77,650,531.93
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-		(44,176,062.71)	-44,176,062.71
Залруулсан үлдэгдэл	189,682,669.33	1,770,000.00	(157,978,200.11)	33,474,469.22
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-		(136,166,418.93)	-136,166,418.93
2023 оны 12 сарын 31-р үлдэгдэл	189,682,669.33	1,770,000.00	(294,144,619.04)	(102,691,949.71)

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1.1	мөнгөн орлогын дүн (+)	1,434,783,292.28	180,782,122.04
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүсний орлого	1,277,465,357.28	170,817,297.04
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	157,317,935.00	9,964,825.00
1.2	Мөнгөн зарлагын дүн(-)	1,434,466,826.08	189,076,376.81
1.2.1	Ажиллагчдад төлсөн	333,148,745.60	36,989,777.85
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	41,708,153.10	5,446,894.70
1.2.3	Бараа материал худалдан авхад төлсөн	944,478,387.16	102,647,710.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	48,059,467.20	10,084,927.20
1.2.5	Түлш, шатхуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	34,502,450.42	1,840,040.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	32,569,622.60	12,013,413.05
1.2.9	Бусад мөнгөн зарлага	0.00	20,053,614.01
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	316,466.20	-8,294,254.77
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	316,466.20	-8,294,254.77
5	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	25,947,437.58	26,263,903.78
6	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	26,263,903.78	17,969,649.01

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Д/д	Зардлын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	дүн
	Орлого	166,898,589.33	167,589,806.70	(691,217.37)	100%
	Нийт ашиг	166,898,589.33	6,014,515.42	160,884,073.91	4%
1	Цалин	37,640,000.00	36,989,777.85	650,222.15	98%
2	Шимтгэл	4,705,000.00	5,446,894.70	(741,894.70)	116%
4	Томилолт	216,000.00	-	216,000.00	0%
5	Хангамжийн материал	600,000.00	3,939,882.20	(3,339,882.20)	657%
6	Сэлбэг	2,500,000.00	2,090,000.00	410,000.00	84%
7	Шатахуун	2,500,000.00	2,084,716.50	415,283.50	83%
9	Цахилгаан	720,000.00	1,145,865.87	(425,865.87)	159%
10	Бичиг хэрэг	600,000.00	600,959.94	(959.94)	100%
11	Холбоо	158,400.00	96,000.00	62,400.00	61%
12	Интернет	1,438,800.00	870,476.97	568,323.03	61%
13	Элэгдлийн зардал	15,000,000.00	16,683,394.26	(1,683,394.26)	111%
14	Биет бус хөрөнгийн хорогдуулга	124,000.00	-	124,000.00	0%
15	Халаалт, цэвэр бохир ус	5,700,000.00	2,922,610.64	2,777,389.36	51%
18	Банкны шимтгэл	100,000.00	54,249.54	45,750.46	54%
19	Үл хөдлөх хөрөнгийн татвар	3,781,014.10	1,890,507.05	1,890,507.05	50%
22	Автомашин татвар	122,872.00	129,436.00	(6,564.00)	105%
23	Газрын төлбөр	50,000.00	6,622.00	43,378.00	13%
24	Хог хаягдлын татвар	350,000.00		350,000.00	0%
29	Актлагдсан эмийн зардал	4,500,000.00	8,602,973.35	(4,102,973.35)	191%
30	Бусад зардал	2,500,000.00	3,760,000.03	(1,260,000.03)	150%
	ҮА-ны зардал дүн	86,666,086.10	90,674,366.90	(4,008,280.80)	105%
3	Ажилчдад тэтгэмж	20,936,810.00	9,566,454.00	11,370,356.00	46%
	Бүгд	20,936,810.00	9,566,454.00	11,370,356.00	46%
	Нийт зардал	107,602,896.10	100,240,820.90	7,362,075.20	93%

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 54,300.0 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 7,700.0 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 46,600.0 мянган төгрөгийн 4 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт хүргүүлээгүй болно.

5.2 Албан шаардлага

1. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйд албан шаардлага өгөв.
2. Он дамнасан муу авлагыг барагдуулаагүй, тус муу авлагаас 7.7 сая төгрөгийн авлагад тооцоо нийлсэн акт үйлдээгүй.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. А А
Илрүүлэлт: Санхүүгийн байдлын тайлан, Орлогын дэлгэрэнгүй тайлан, Мөнгөн гүйлгээний тайлангийн уялдаа холбоог шалгаж үзэхэд борлуулалтын орлого, мөнгөн орлого хооронд 13.5 сая төгрөгийн зөрүүтэй илэрхийлэгдсэн байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн тайлангуудыг үнэн зөв бэлтгэж үнэн зөв толилуулах

2 Э А А А А А

Илрүүлэлт: Бараа материалын эцсийн үлдэгдлийг санхүү байдлын тайлангийн эхний эцсийн үлдэгдэл, Үр дүнгийн тайлангийн өртөг, Мөнгөн гүйлгээний тайлангийн бараа материал худалдан авсан мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайланд хийгдсэн залруулга, санхүүгийн тайлангийн тодруулга болон бусад журнал, аудитад ирүүлсэн бусад тайлангуудтай зэрэгцүүлж үзэхэд тайлангуудын мэдээлэл хооронд уялдаа холбоогүй материаллаг зөрүүтэй байна.

Өгсөн зөвлөмж:

Тайлангуудын мэдээлэл хоорондын уялдаа холбоог үнэн зөв нягтлан бэлтгэх

3. Өр төлбөр хуримтлуулснаас болж алданги төлсөн асуудал.

Илрүүлэлт: Азифарм ХХК-д төлөх 116.8 сая төгрөгийн өр төлбөрт гэрээний дагуу тайлант онд нийт 33.1 сая төгрөгийн алданги төлсөн.

Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8.Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх гэсэн заалтыг мөрдөж ажиллах зөвлөмж хүргүүлэв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад
талархал илэрхийлье.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Өмнөх оны зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаагүй	1				1							
Бараа материалын эцсийн үлдэгдлийг санхүү байдлын тайлангийн эхний эцсийн үлдэгдэл, Үр дүнгийн тайлангийн өртөг, Мөнгөн гүйлгээний тайлангийн бараа материал худалдан авсан мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайланд хийгдсэн залруулга, санхүүгийн тайлангийн тодруулга болон бусад журнал, аудитад ирүүлсэн бусад тайлангуудтай зэрэгцүүлж үзэхэд тайлангуудын мэдээлэл хооронд уялдаа холбоогүй материаллаг зөрүүтэй байна.	1	-					1	-				
Он дамнасан муу авлагыг барагдуулаагүй, тус муу авлагаас 7,7 сая төгрөгийн авлагад тооцоо нийлсэн акт үйлдээгүй.	1	7,700.0			1	7700.0						
Азифарм ХХК-д төлөх 116,8 сая төгрөгийн өр төлбөрт гэрээний дагуу тайлант онд нийт 33,1 сая төгрөгийн алданги төлсөн.	1	33,100.0					1	33,100.0				
Санхүүгийн байдлын тайлан, Орлогын дэлгэрэнгүй тайлан, Мөнгөн гүйлгээний тайлангийн уялдаа холбоог шалгаж үзэхэд борлуулалтын орлого, мөнгөн орлого хооронд 13,5 сая төгрөгийн зөрүүтэй илэрхийлэгдсэн байна.	1	13,500.0					1	13500.0				
ДҮН	5	54,300.0	-	-	2	7700.0	3	46,600.0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны тухай хуульд заасан хөрөнгө, мөнгө, зарцуулах тухай захирлын А тушаалыг, шилэн дансанд байршуулсан мэдээлэлтэй тулган шалгахад Хөрөнгө зарцуулах тухай Хөрөнгө зарцуулах тухай 2 тушаалыг хугацаа хоцроож оруулсан зөрчилтэй байна.	1	-			-		1	
Дүн	1	-			-		1	